



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



ХИМИ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:


САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР


1. Зурагт X үсгээр тэмдэглэсэн бодис нь ямар төлөвтэй вэ?

- A. хий B. хатуу C. шингэн D. плазма



Анхаараарай !!!

Доорх өгөгдлийг ашиглан 2, 3, 4, 5, 6 – р асуултад хариулаарай.



2. Тасалгаанд байгаа дараах бодисуудаас жижиг хэсгийг нь дээрх зургийн 1 дугаартай бодисын загвараар илэрхийлэх боломжтой бодисыг нэрлэнэ үү.

- A. сүү B. тараг C. усны уур D. төмөр

3. Нэгэн бодис төлөвийн шилжилтэд орсон нь дээрх зургийн 2 дугаартайгаас 3 дугаартай руу шилжсэн гэж үзвэл энэ бодис ямар төлөвийн шилжилтэд орсон бэ?

- A. хайлах B. царцах C. уурших D. конденсацлах

4. Дээрх зурагт дугаарласан гурван бодисын алинд нь жижиг хэсгийн хөдөлгөөн хамгийн удаан вэ?

- A. 1 B. 2 C. 3 D. 1, 3

5. Дээрх зурагт дугаарласан гурван бодисын жижиг хэсэг хоорондын таталцлын хүч ихсэх дараалалд оруулсан эгнээг сонгоорой.

- A. 1 → 2 → 3 B. 3 → 2 → 1 C. 2 → 1 → 3 D. 3 → 1 → 2

6. Өөрийн гэсэн хэлбэр дүрсгүй, савныхаа эзлэхүүнээр, жижиг хэсэг нь эмх цэгцгүй, хол байрлаж, байнгын эмх замбараагүй хөдөлгөөнд оршдог гэсэн тодорхойлолт аль бодисыг нь тодорхойлж байна вэ?


- A. 1 B. 2 C. 3 D. 1, 3

7. Зурагт шингэнийг ямар шинж чанартай материалаар хийсэн савд юүлсэн байна вэ?

- A. тунгалаг бус
- B. тунгалаг
- C. бат бэх
- D. хэврэг



8. Доорх жишээнүүдээс аль нь металлын уян шинж чанарыг харуулж байна вэ?



9. Төмөр шугамыг ямар шинж чанарт нь үндэслэн нугалдаг вэ?

- A. нягт их
- B. гялтганах
- C. давтагдах
- D. уян харимхай

10. Барилгын ханыг гаднаас нь хөөсөнцрөөр давхарладаг хөөсөнцрийн ямар шинж чанарт үндэслэж байна вэ?

- A. дулаан муу дамжуулна
- B. давтагдах
- C. нягт их
- D. гялтганах

11. Дараах материалуудаас цахилгаан дамжуулахгүй шинж чанартайг нь сонгоно уу.

1	төмөр утас	4	зэсэн аяга
2	хуванцар сав	5	алчуур
3	модон аяга	6	мөнгөн халбага

- A. 2, 3, 1
- B. 2, 3, 5
- C. 2, 3, 4
- D. 2, 3, 6

12. Аль уусмалд лакмусын улаан цаасыг дүрэхэд хөх өнгөтэй болох вэ?

- A. сул хүчиллэг
- B. хүчиллэг уусмал
- C. саармаг уусмал
- D. суурилаг уусмал

13. Үл мэдэгдэх өнгөгүй уусмалд метилоранжийн уусмалаас 2 – 3 дуслыг дусаахад уусмал улаан өнгөтэй болжээ. Уусмал ямар орчинтой байсан бэ?

- A. суурилаг
- B. хүчиллэг
- C. сул суурилаг
- D. саармаг

14. Шүдний оо – ны уусмал дээр хүрэн байцайны индикатор дусаахад уусмал ямар өнгөтэй болох вэ?

- A. ягаан
- B. шар
- C. ногоон
- D. улаан

15. Содын уусмал нь суурилаг шинжтэй, кока кола нь хүчиллэг орчинтой. Хэрэв кока кола дээр содыг бага багаар нэмэх үед уусмалын орчин хэрхэн өөрчлөгдөхийг таамаглана уу.

- A. суурилгаас саармаг, суурилаг
B. хүчиллэгээс саармаг
C. суурилгаас саармаг
D. хүчиллэгээс саармаг, хүчиллэг

16. Химийн лабораторт бодисын шошго дээр аюулгүйн тэмдэг тавьсан байдаг. Хүчил агуулсан савны гадна талд яагаад зурагт үзүүлсэн тэмдэг байрлуулсан бэ?

- A. хүчил нь дэгдэмхий
B. хүчил асгарч болзошгүй
C. хүчил нь арьс салстыг түлдэг учраас
D. хүчил исгэлэн амттай, лакмусд улаан өнгө үзүүлдэг



17. Хүчиллэг борооны эх үүсвэр БОЛДОГГҮЙ үзэгдлийг олоорой.

- A. ус буцлахад гарах уур
B. нүүрс шатаахад гарах утаа
C. үйлдвэрийн яндангаас гарах утаа
D. хөрсийг бордох

18. Эдгээрийн аль нь хүчиллэг борооны шууд үр дагавар вэ?

- A. ойн түймэр
B. дэлхийн дулаарал
C. озоны цоорол
D. усны амьтад үхэх

19. Ихэнх ургамал ургахад таагүй орчинг бүрдүүлэхийн тулд ямар уусмалаар услах вэ?

- A. саармаг уусмал
B. хүчлийн уусмал
C. сул суурилаг уусмал
D. суурилаг уусмал

20. Усны бохирдлоос сэргийлэх үр дүнтэй аргуудыг сонгоорой.

- I. усны ундарга дээр мод тарьж, хашаалах
II. хогийг зориулалтын газар хаях
III. голын эрэг дээр хог хаях

- A. I, II
B. II, III
C. I, III
D. I, II, III